



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит
/хураангуй/

Аудитын код: **ӨВА-2025/182/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Өвөрхангай аймаг,
Арвайхээр сум

2025 он

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: П.Хорлоосүрэн

Утас: 70323108 Цахим хаяг: KhorloosurenP@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэцэцэг

Утас: 70323108 Цахим хаяг: Erdenetsetsegb@audit.gov.mn

Аудитор: Э.Энхбаяр

Утас: 70323108 Цахим хаяг: Enkhbayare@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 119
танай _____-ны № _____-т

ХАРХОРИН СУМЫН ОРОН
НУТГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРАЛ Д.ЭНХЗАЯА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хархорин сумын орон нутгийн нэгдсэн эмнэлгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Хархорин сумын Нэгдсэн эмнэлэг нь сумын 15,000 орчим, мөн Өвөрхангай, Архангай, Булган аймгуудын 7 сумын 28,000 гаруй иргэнд төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг. Тайлант онд амбулаториор 71,608, яаралтай тусламжаар 4,778, хэвтэн эмчлүүлэгчээр 4,077, мээ засал, ажилбараар 424 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Түүнчлэн, тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилтээр 5,864.4 сая төгрөгийг нэхэмжилснээс 5,352.0 сая төгрөгийг авсан бөгөөд эрүүл мэндийн даатгалын сангийн хяналтаар 512.3 сая төгрөг хасагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагчид бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудал

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

6225020088

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,683,476.8	1,104,608.3
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,629,376.4	5,620,697.0
	Нийт хөрөнгийн дүн	6,312,853.2	6,725,305.4
	Нийт өр төлбөрийн дүн	156,731.4	396,893.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,156,121.9	6,328,412.4
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,312,853.2	6,725,305.4
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	7,659,532.6	7,555,909.5
	Үйл ажиллагааны зардлын дүн	5,255,680.7	7,383,618.9
	Үйл ажиллагааны үр дүн	2,403,851.9	172,290.5
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	2,403,851.9	172,290.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,752,270.0	6,156,121.9
	Тайлант оны үр дүн	2,403,851.9	172,290.5
	Эцсийн үлдэгдэл	6,156,121.9	6,328,412.4
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	3,818,796.1	7,212,896.3
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,081,063.4	6,442,803.0
	Үйл ажиллагааны ЦМГ	(262,267.3)	770,093.3
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(97,151.9)	(2,155,755.1)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(359,419.2)	(1,385,661.8)
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,783,316.7	1,423,897.6
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,423,897.6	38,235.8
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,178,215.3	8,544,042.4
	Урсгал зардал	4,178,215.3	8,544,042.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	5,602,112.9	7,158,380.6
	Улсын төсвөөс санхүүжих	-	393,000.0
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	105,988.6	141,202.3

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.9 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 6.9 сая төгрөгийн алдааг залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилагдсан 3 төрлийн 3.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, Үндсэн хөрөнгийн ангилалд хамаарах 3,289.9 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. Энэхүү залруулсан НББ-ийн алдаа нь нийт зөрчлийн дүнд орохгүй.

Аудитаар нийт 4,593.2 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 4,568.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 25.2 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт өгөгдөөгүй

3.2 Албан шаардлага

1. Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан 326,045.1 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 1,534,341.1 мянган төгрөгийн зарлагын 32 гүйлгээ болон хуулийн 6.4.8-д заасан 2,707,643.9 мянган төгрөгийн худалдах, худалдан авах 34 төрлийн гэрээ байршуулаагүй, орлогын 37 гүйлгээ, зарлагын 65 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж санхүүгийн үнэн зөв, ил тод байдлыг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас 29 хүний шагналын мөнгө болох 25,200.0 мянган төгрөгийг эд хариуцагчийн дансанд бөөн дүнгээр шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нэг хүнд бөөн дүнгээр шилжүүлэх нь мөнгийг буруугаар ашиглах, татварын тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлтэй тул цаашид Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны "Төсвийн байгууллагын мөнгөн кассын журам"-ыг мөрдөж ажиллах.

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрүүл мэндийн даатгалын сангаас 5,864.4 сая төгрөг нэхэмжилснээс 5,352.0 сая төгрөгийн санхүүжилт авч хяналтаар 512.4 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2."батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой" байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрүүл мэндийн үндсэн тусламж үйлчилгээний нэхэмжлэхийн баримтын бүрдүүлэлт болон шалгуурт хяналт тавьж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Үнэ төлбөргүй шилжиж ирсэн 3 төрлийн хөрөнгийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй	1	3,585.6	1	3,585.6			1	3,585.6				
2. Үндсэн хөрөнгийн ангилалд хамаарах тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.	1	3,289.9			1	3,289.9	1	3,289.9				
Дүн	2	6,875.5	1	3,585.6	1	3,289.9	2	6,875.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас 29 хүний шагналын мөнгө болох 25,200.0 мянган төгрөгийг эд хариуцагчийн дансанд бөөн дүнгээр шилжүүлсэн байна.	1	25,200.0	0	0	0	0	1	25,200.0				

Хархорин сумын Нэгдсэн эмнэлгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Эрүүл мэндийн даатгалын сангаас 5,864.4 сая төгрөг нэхэмжилснээс 5,352.0 сая төгрөгийн санхүүжилт авч хяналтаар 512.4 сая төгрөгийн санхүүжилт хасагдсан байна.	1	0					1	0				
Дүн	2	25,200.0					2	25,200.0				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд орлогын 8 гүйлгээ, зарлагын 32 гүйлгээ болон худалдах, худалдан авах 34 төрлийн гэрээ байршуулаагүй, орлогын 37 гүйлгээ, зарлагын 65 гүйлгээг хугацаа хоцроон байршуулсан байна.	1	4,568,030.1			1	4,568,030.1		
Дүн	1	4,568,030.1			1	4,568,030.1		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
	0	0	0	0	0	0	0	0
Дүн	0	0			0	0		
Нийт дүн	3	4,593,230.1	0	0	3	4,593,230.1	0	0

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР